

Төрийн албаны зөвлөлийн
2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн
084 дүгээр тогтоолын 77 дугаар хэвсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай
хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
хууль (2023.01.06)

Дагаж мөрдөх огноо:

2023.03.01

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

24 06 27

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Гадаадын иргэн, харьяатын газар

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын
хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Аудит хариуцсан мэргэжилтэн

Дэс түшмэл, ТТ-7

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдрийн 8 цаг

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Буянт-
Ухаа дэнж, Гадаадын иргэн, харьяатын
газрын төв байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Албан ажлын онцгой нөхцөлд хамаарна.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ


Албан тушаалын зорилго:

Байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх, зөрчил дутагдлыг арилгуулах, урьдчилан
сэргийлэх арга хэмжээ авах, үйл ажиллагааг сайжруулах талаар дүгнэлт, зөвлөмж
боловсруулах, удирдлагыг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг
нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:


1. Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод аудитыг гүйцэтгэж удирдлагыг шийдвэр гаргах түвшний мэдээллээр хангах;
2. Төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбогдолтой хууль тогтоомж, стандарт, гэрээг мөрдэж байгаа эсэхэд хяналт тавьж, үр нөлөөг сайжруулах санал боловсруулах, зөвлөн туслах;
3. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| | | | |
|---------------------------|--|---|---|
| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т Гүйцэтгэх-Г Хянах-X Шийдвэрлэх -Ш |
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Дотоод аудитын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж болон дотоод аудитын мэргэжил практикийн олон улсын стандартад нийцсэн, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захирагааны төв байгууллагаас баталсан арга зүйн хүрээнд гүйцэтгэх; | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн шийдвэр гаргасан байна. | Г |
| | 2. Хуулиар олгосон эрхийн хүрээнд хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үр дүнд үндэслэн зөвлөмж боловсруулах; | Зохих журмын дагуу хяналт шинжилгээ хийж, үр дүнг танилцуулсан байна. | Г |
| | 3. Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалт, өмчлөлд хяналт тавих; | Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавьсан байна. | Г |
| | 4. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус гүйцэтгэлийн аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлж, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, холбогдох газарт хүргүүлэх; | Хууль тогтоомжид нийцсэн байна | Т, Г |
| | 5. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн зөвлөмж боловсруулан холбогдох нэгжид хүргүүлэх, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавих; | Хууль тогтоомжид нийцсэн байна | Т |
| | 6. Аудит хийх сэдвийн төлөвлөгөө, хуваарийн дагуу гүйцэтгэх нийцлийн аудитын төлөвлөгөө, төсөв, зардал, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах. | Хууль тогтоомжид нийцсэн байна | Г |

| | | | |
|---------------------------|---|--|-----|
| | 1.Төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдалд хяналт тавьж ажиллах; | Зохих журмын дагуу хяналт тавьсан байна. | Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 2.Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдалд хяналт тавих; | Холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьсан байна. | Т,Г |
| | 3.Төсвийн ерөнхийлөн захирагч болон тухайн байгууллагын даргын шийдвэрээр тусгайлан явуулах бусад аудит хийх; | Зохих журмын дагуу хяналт шалгалт хийж, аудитын дүнг бодитой, үнэн зөв тайлагнасан байна. | Т,Г |
| | 4.Төсвийн төвлөрүүлэн захирагч болон шууд захирагчийн шийдвэрээр тусгайлан явуулах бусад аудитыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллах; | Зохих журмын дагуу хяналт шалгалт хийж, аудитын дүнг бодитой, үнэн зөв тайлагнасан байна. | Т,Г |
| | 5.Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, холбогдох газарт хүргүүлэх. | Холбогдох хууль, журмын хэрэгжилт хангагдсан байна. | Т,Г |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Захиргааны ерөнхий, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам” болон бусад хуульд тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх; | Хууль тогтоомжид нийцсэн байна. | Г |
| | 2.Эрхэлсэн ажлын чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хариуцаж, зөрчил дутагдал гаргасан тохиолдолд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх; | Хууль тогтоомжид нийцсэн байна. | Г |
| | 3.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг сахиж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг биелүүлэх; | Хууль тогтоомжид нийцсэн байна. | Г |
| | 4.Хөрөнгө орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргах; | Хууль тогтоомжид нийцсэн байна. | Г |
| | 5.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомж, заавар, зөвлөмж, журам стандартад нийцсэн баримт бичгийн төсөл боловсруулах; | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн  | Г |

| | | | |
|--|---|--|---|
| | 6. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах; | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, үнэлгээ | Г |
| | 7. Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх; | Гүйцэтгэлийн хувь | Г |
| | 8. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох. | Оролцсон арга хэмжээний тоо | Г |

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| | | | |
|-----------|--|---|---|
| Боловсрол | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй. | | |
| Мэргэжил | <ul style="list-style-type: none"> -эрх эүй (0421); -нягтлан бодох бүртгэл, татвар (0411); -эдийн засаг (0311); -статистик (0542). | | |
| Мэргэшил | Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр гадаад, дотоодын сургалтад хамрагдсан байх. | | |
| Туршлага | Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно. | | |
| | Дүн шинжилгээ хийх | <ul style="list-style-type: none"> - баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан тушаалын чиг үргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - нэгжийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, үр дүнг тайлагнах; - бусад. | |
| Үр чадвар | Асуудал шийдвэрлэх | <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн, оновчтой шийдвэрийг шуурхай гаргах; - асуудлыг хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх; - бусад. | |
| | Багаар ажиллах | <ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонгой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлах; - бусадтай харилцан итгэл терүүлэхүйц ажил хэрэгч харилцаа бий болгох; - ажил хэрэгч, бүтээлч, санаачилгатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглахын хувьд бусдыг манлайлах; - бусад. |  |

| | | |
|--|-------|---|
| | Бусад | <ul style="list-style-type: none"> - албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтэй аргыг ашиглах; - бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах. |
|--|-------|---|

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн дарга

| | |
|---|---|
| Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект: |
| | <ul style="list-style-type: none"> - Яам, агентлаг, төрийн бусад байгууллага, тэдгээрийн ажлын албаны холбогдох албан тушаалтан; - Байгууллагын зохион байгуулалтын нэгж, холбогдох албан тушаалтан; - Иргэн хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага. |

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| | |
|--|--|
| Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
| Албан тушаал: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА И.БААТАРХҮҮ 2024 оны 06 сарын 19 -ны өдөр 1116126983 2712253 | Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо:..... Дугаар: 284 24 06 19 |

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

| | |
|---|---|
| Байгууллагын нэр: ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР Шийдвэрийн огноо: 2024.06.27 Дугаар: А/С (тамга/тэмдэг) | ДАРГА..... Н.УУГАНБАЯР (Гарын үсэг) (Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр) 2024 оны 06 дугаар сарын 27 -ны өдөр |
|---|---|

1116126983
ТУЗ1614 & 91289561